



"Ай Жэй Эй Эйч-Аудит" ХХК

“АЛТАЙН ЗАМ ” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон
Санхүүгийн аудитын тайлан

Улаанбаатар хот
2022

АГУУЛГА

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	2
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ЗАХИДАЛ.....	3
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	7
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	8
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	10
ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	11
ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ.....	11
ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС.....	19
ТОДРУУЛГА 4. АВЛАГА	19
ТОДРУУЛГА 5. БАРАА МАТЕРИАЛ.....	19
ТОДРУУЛГА 6. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ ТООЦОО.....	20
ТОДРУУЛГА 7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20
ТОДРУУЛГА 8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ.....	20
ТОДРУУЛГА 9. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР.....	21
ТОДРУУЛГА 10. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21
ТОДРУУЛГА 11. ХУВЬЦААТ КАПИТАЛ.....	21
ТОДРУУЛГА 12. ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ.....	21
ТОДРУУЛГА 13. БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ.....	22
ТОДРУУЛГА 14. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ	22
ТОДРУУЛГА 15. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ	22

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр /Оноосон нэр/	Монгол	"Алтайн зам" ХК
Компаний удирдлага	Б.Энхбат	Гүйцэтгэх захирал
Компанийн хаяг:	Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Баатархайрхан, Алтайн зам ХК-ийн байр	
	Утас: (976)-11-22027	
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:	1610001001	
Регистрийн дугаар:	2033003	
Бүртгэгдсэн он сар	2006.03.31	
Үйл ажиллагааны чиглэл	Зам, гүүр барих засварлах, Аэродром барих, засварлах, Гадаад, дотоод худалдаа, Хуурай замаар хийгдэх ачаа тээвэр үйл ажиллагаа	
Санхүү	Э.Өлзийхутаг	Нягтлан бодогч
Ажилчдын тоо	620 орчим ажилчидтай	
Аудитын компани	"Ай Жэй Эй Эйч -Аудит" ХХК Нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага	
Аудитын компанийн хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Намьяанжүгийн гудамж , "Corper plaza" 502,503 тоот Утас: 976-77450279, 99040059 Факс: 976-77450279,	

2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлангийн 5-6 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “ Алтайн зам ” Хувьцаат Компанийн /Компани гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хяриуцлагыг ялгах үүднээс хийгдсэн болно.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- ✓ Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдөх
- ✓ Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- ✓ СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- ✓ Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг үйл ажиллагааны суурийг үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- ✓ Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловруулж, хэрэгжүүлж ажиллуулах
- ✓ Компаний санхүүгийн байдлыг аливаа хугацаанд үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх
- ✓ Компаний нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- ✓ Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ✓ Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.
- ✓ 2019 оны сүүлээр COVID-19 (Коронавирус)-ийн тухай Хятад улс анх мэдээлсэн бөгөөд 2020 оны 11-р сард дотоодын эхний тохиолдолд Монгол улсад бүртгэгдсэн. 2021 оны байдлаар нэмэлт тохиолдлууд бүртгэгдсээр байна. Хэдийгээр санхүүгийн тайлан гаргах үед уг нөхцөл байдал хувьсан өөрчлөгдөж байгаа ч өнөөдрийг хүртэл “Алтайн зам” ХК-ийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй байна. Гэвч, ирээдүйд болох үйл явдлыг урьдчилан тааварлах боломжгүй юм. Бид болзошгүй нөлөөллийг үргэлжлүүлэн хянахын сацуу аливаа нөлөөг

бууруулах бүх боломжит арга хэмжээг авах болно.

- ✓ Санхүүгийн тайланг батлах өдөр болон энэхүү захидал зурагдах өдрийн хооронд санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц өөр үйл явдал гараагүй

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Алтайн зам” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.


Б.Энхбат
/Гүйцэтгэх захирал/


Э.Өлзийхутаг
/Нягтлан бодогч/



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА

“Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК

20...он...сар...өдөр

№ 06/2022

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Алтайн зам” ХК -ийн хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Зөрчилгүй дүгнэлт

“Алтайн зам” ХК -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Алтайн зам” ХК -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторовн үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангийн талаархи компаний удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компаний дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компаний санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Мөн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлсон.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 4-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Алтайн зам" ХК -ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ай Жэй Эй Эйч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2022. 01.31

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

/мянган.төгрөгөөр/

	2020	2021
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	3,051,909.6	97,898.4
Дансны авлага	3,987,503.4	3,099,097.4
Татвар, НДШ-ийн авлага	971.0	7,758.3
Бусад авлага	17,352,121.5	17,167,820.6
Бараа материал	2,962,772.8	4,662,663.9
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	718,155.4	282,343.5
Эргэлтийн хөрөнгийн дүн	28,073,433.7	25,317,582.1
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	23,587,062.3	29,018,612.1
Биет бус хөрөнгө	23,563.4	51,827.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	23,610,625.7	29,070,439.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	51,684,059.4	54,388,021.4
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	3,110,064.1	5,047,856.5
Цалингийн өглөг	4,776.6	20,621.9
Татварын өглөг	2,103,313.5	1,968,790.9
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	46,174.8	38,544.7
Банкны богино хугацаат зээл	22,923,492.0	18,162,807.3
Хүүний өглөг	12,091.1	4,780.1
Урьдчилж орсон орлого	41,880.0	15,000.0
Нөөц /өр төлбөр/	57,149.6	48,600.8
Бусад богино хугацаат өр төлбөр	1,969,623.1	4,663,957.9
Богино хугацаат өр төлбөрийн дүн	30,268,564.8	29,970,960.1
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	8,030,222.1	9,424,063.1
Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,030,222.1	9,424,063.1
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	38,298,786.9	39,395,023.2
Эздийн өмч		
Өмч / хувийн /	5,415.3	5,415.3
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	631,113.1	631,113.1
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	12,748,744.1	14,356,469.8
Эздийн өмчийн дүн	13,385,272.5	14,992,998.2
Нийт өр төлбөр, өмчийн дүн	51,684,059.4	54,388,021.4

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

ОРЛОГЫН ТАЙЛАН

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	/мянган.төгрөгөөр/
	2021
Борлуулалтын орлого	64,916,740.2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	60,492,021.8
Нийт ашиг (алдагдал)	4,424,718.4
Хүүний орлого	54.4
Бусад орлого	27,272.7
Борлуулалт маркетингийн зардал	-
Ерөнхий ба удирдлагын зардал	2,793,890.0
Санхүүгийн зардал	-
Бусад зардал	2,059.8
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,504.8)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (гарз)	40,015.3
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,693,606.2
Орлогын татварын зардал	17,139.2
Татварын дараах ашиг (алдагдал)	1,676,467.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,676,467.0


Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	/мянган.төгрөгөөр/			
	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагд-сан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31	5,415.3	631,113.1	12,748,744.1	13,385,272.5
Гаргасан хувьцаат капитал				-
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө , алдааны залруулга			(68,741.3)	(68,741.3)
Залруулсан үлдэгдэл	5,415.3	631,113.1	12,680,002.8	13,316,531.2
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал			1,676,467.0	1,676,467.0
Бусад дэлгэрэнгүй орлого				
2021 оны 12 сарын 31	5,415.3	631,113.1	14,356,469.8	14,992,998.2

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

/мянган.төгрөгөөр/

2021

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	80,533,387.80
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	80,532,160.40
Буцаан авсан албан татвар	227.30
Бусад мөнгөн орлого	1,000.10
Мөнгөн зарлагын дүн (-)	43,078,853.50
Ажилчдад төлсөн	4,141,132.60
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,027,946.30
Бараа материал худалдан авахад төлсөн	32,848,389.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	214,038.40
Хүүний төлбөрт төлсөн	2,140,518.70
Татварын байгууллагад төлсөн	2,656,403.80
Даатгалын төлбөрт төлсөн	178.20
Бусад мөнгөн зарлага	50,246.50
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	37,454,534.30
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	3,086,683.30
Бусдаас авсан зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,086,628.90
Хүлээн авсан хүүний орлого	54.40
Мөнгөн зарлагын дүн (-)	46,243,495.80
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	46,243,495.80
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(43,156,812.50)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	66,594,099.70
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	66,594,095.00
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	4.70
Мөнгөн зарлагын дүн (-)	63,844,166.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	63,844,166.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,749,933.70
Валютын ханшийн зөрүү	(1,666.80)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,954,011.20)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,051,909.60
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,898.40

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.